

БАТЛАВ.

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА...../ Б.Буяннэмэх/

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“ХАН ХАС ТРЕЙД” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ...../М.Төрмөнх/



**ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ-УГТААЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ
БУМБАТЫН ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН АШИГЛАЛТЫН ТАЛБАЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/Газрын тос ашиглах тусгай зөвшөөрлийн дугаар: 4386А/

/Регистрийн дугаар: 2787318/

Хянасан:

БОАЖЯ-НЫ ХБОБНГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ...../Ц.Жаргалнэмэх/

Боловсруулсан:

“Хан Хас Трейд” ХХК-ний
мэргэжилтэн...../Б.Жаргалням/

АГУУЛГА

| | |
|---|----|
| 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА..... | 3 |
| 1.1 Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл..... | 3 |
| 1.2 Ордын байршил..... | 4 |
| 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ОНЦЛОГ..... | 6 |
| 2.1 Физик газарзүйн нөхцөл..... | |
| 2.2 Уур амьсгал..... | 7 |
| 2.3 Агаар орчин | 9 |
| 2.4 Гадаргын ус..... | 9 |
| 2.5 Газрын доорх ус..... | 9 |
| 2.6 Хөрсөн бүрхэвч..... | 9 |
| 2.7 Ургамлан нөмрөг..... | 10 |
| 2.8 Амьтан | 11 |
| 2.9 Зам..... | 11 |
| 3. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ..... | 12 |
| 3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө..... | 12 |
| 3.2. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө..... | 13 |
| 3.3. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө..... | 14 |
| 3.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө..... | 14 |
| 3.5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө..... | 15 |
| 3.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө..... | 16 |
| 3.7. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө..... | 16 |
| 3.8 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2023 төсөв..... | 16 |

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1 MV-10665 тоот тусгай зөвшөөрлийн газарзүйн солбицол. **Error! Bookmark not defined.**

Хүснэгт 1.2 2012-2013 онд олборлосон нөөц **Error! Bookmark not defined.**

Хүснэгт 1.3 Ил уурхайн ажлын горим **Error! Bookmark not defined.**

Хүснэгт 1.4 Уурхайн ашиглалтын технологи **Error! Bookmark not defined.**

Дундговь аймгийн Говь-Угтаал суманд байрлах MV-004386 тоот тусгай зөвшөөрөлтэй бумбатын хайлуур жоншны ордны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 1.5 Хуулах шимт хөрсний хэмжээ /ашиглалтын жил бүрээр/.. **Error! Bookmark not defined.**

Хүснэгт 1.6 Овоолгын үндсэн хэмжээ..... **Error! Bookmark not defined.**

Хүснэгт 1.7 Хөрсний овоолгын төлөвлөлт..... **Error! Bookmark not defined.**

Хүснэгт 1.8 Тоног төхөөрөмжийн нэгдсэн хүснэгт..... **Error! Bookmark not defined.**

Хүснэгт 1.9 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....12

Хүснэгт 1.10 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө..... 13

Хүснэгт 1.11 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....14

Хүснэгт 1.12 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....14

Хүснэгт 1.13 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө.....15

Хүснэгт 1.14 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....16

Хүснэгт 1.15 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....16

Хүснэгт 1.16 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2023 төсөв.....16

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1 Уурхайн сансраас харагдах байдал **Error! Bookmark not defined.**

НЭГ. УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн ерөнхий мэдээлэл, танилцуулга

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутагт “Бумбат” нэртэй MV-004386 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Ханхас трейд” ХХК-д АМГТГ-аас 2007 оны 01-р сарын 29-ны өдөр 30 жилийн хугацаагаар олгосон. “Ханхас трейд” ХХК нь “Бумбат” нэртэй хайлуур жоншны ордыг түшиглэн уурхай байгуулж орон нутгийн нийгэм, эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулсан компани болохоор зорин ажиллаж байна.

“Ханхас трейд” ХХК нь 2006-2007 онд хайгуулын ажил хийж, хайлуур жоншны хүдрийн биетэд бодитой зэрэглэлээр нөөц тогтоож, бодитой В болон боломжтой С зэргээр үнэлгээ өгч 2008 оны 6-р сард Эрдэс баялгийн зөвлөлөөр хэлэлцүүлэн ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн.

“Бумбат” хайлуур жоншны ордын нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2008 оны 06 сарын 17-ны өдрийн хуралдаанаар 24-03 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан, АМГТХЭГ-ын даргын 2008 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 329 тоот тушаалаар хүдрийн бодитой (В) зэргийн нөөцийг 59015.24 тн, 42.77 %-ийн дундаж агуулгатай эрдэс 25241.6 тн, хүдрийн боломжтой (С) зэргийн нөөцийг 29741.2 тн, 44.58 %-ийн дундаж агуулгатай эрдэс 13258.67 тн, хүдрийн бодитой болон боломжтой (В+С) нөөцийг 88756.44 тн, 43.38 %-ийн дундаж агуулгатай эрдэс 38500.27 тн-оор тус тус Улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна. Тус ордын үлдэгдэл нөөц 2017 оны 01дүгээр сарын 01-ний байдлаар хүдрийн бодитой (В) зэргийн нөөц 27430 тн, 38.06 –ийн дундаж агуулгатай эрдэс 10440 тн, хүдрийн боломжтой (С) зэргийн нөөц 29741.2 тн, 44.58 %-ийн дундаж агуулгатай эрдэс 13258.67 тн, хүдрийн бодитой болон боломжтой (В+С) нөөц 57171.2 тн, 41.45 %-ийн дундаж агуулгатай эрдэс 23698.67 тн тус тус байхаар тооцсон байна. Мөн далд уурхайн хүрээн дэх хаягдал дунджаар 8.4 %, бохирдолт 11.6 % бөгөөд нийт 58.46 мян.тн хүдэр олборлож, 21.7 мян.тн CaF₂ тус тус байна.

Ордын хүдрийн биетийн тогтоц, хэвтээ зузаан, агуулагч чулуулгийн шинж чанар зэрэг гол үзүүлэлтүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр уг далд уурхайд шпурын цэнэгийн аргаар хоршоолон нураах ашиглалтын системээр ашиглахаар сонгосон.

Тус ордыг далд уурхайн аргаар 3 жил ашиглах төслийн тооцоог хийсэн бөгөөд жилд дунджаар 25.0 мян.тн хүдэр олборлон гар аргаар ялгаж, ФК-75 маркийн бүхэллэг жонш, болон дунджаар 32.7 % агуулгатай хүдэр тус тус борлуулахаар төлөвлөж байна.

Дундговь аймгийн Говь-Угтаал суманд байрлах MV-004386 тоот тусгай зөвшөөрөлтэй бумбатын хайлуур жоншны ордны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө


Ордын тогтоогдсон нөөцийг зохистой технологиор байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, эдийн засгийн үр ашигтай ордыг ашиглах зэрэг холбогдох асуудлыг энэхүү төслийн хүрээнд авч үзлээ.

Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээр эрдэс түүхий эдийн үнэ өсөх хандлагатай байгаа тул улс орныхоо эрдэс баялгийг зэх зээлийн эргэлтэд шуурхай оруулж эдийн засгийн чадамжийг өсгөх таатай нөхцөл бүрдэж байгаа энэ боломжийг зүй зохистой ашиглах нь чухал юм.


Хүснэгт 1. MV-004386 тоот тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд

| № | Өргөрөг | Уртраг |
|---|---------------|----------------|
| 1 | 450 48 21.61 | 1070 35 28.55 |
| 2 | 450 48 21.61 | 1070 35 1.55 |
| 3 | 450 48 41.62 | 1070 35 1.55 |
| 4 | 450 48 41.62 | 1070 35 28.55 |
| 5 | 450 48 21.61 | 1070 35 28.55 |

Дундговь аймгийн Говь-Угтаал суманд байрлах MV-004386 тоот тусгай зөвшөөрөлтэй бумбатын хайлуур жоншны ордны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 1. Бумбатын хайлуур жоншны ордны байршил



Зураг 2. Бумбатын хайлуур жоншны ордны байршил

Дундговь аймгийн Говь-Угтаал суманд байрлах MV-004386 тоот тусгай зөвшөөрөлтэй бумбатын хайлуур жоншны ордны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1.ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ОНЦЛОГ

Төслийн хүчин чадал

Ордыг далд уурхайн аргаар 3 жил ашиглах бөгөөд жилд дунджаар 25.0 мян.тн хүдэр олборлон гар аргаар ялгаж, ФК-75 маркийн бүхэллэг жонш, болон дунджаар 32.7 % агуулгатай хүдэр тус тус борлуулна. Тус далд уурхай нь ашиглалтын нийт хугацаанд 37.17 %-ийн дундаж агуулгатай 58465 тн хүдэр олборлож металлургийн баяжмал болох ФК-75 маркийн бүхэллэг жоншыг гар аргаар ялган авч ОХУ-д экспортод гаргах ба үлдэгдэл бага агууллагатай хүдрийг тухайн бүс нутагт байрлах дотоодын баяжуулах үйлдвэрүүдэд далд уурхайн ам нөхцөлөөр борлуулна.

Нийгэм-эдийн засаг: Тусгай зөвшөөрлийн талбай байрлах Дундговь аймгийн Говь-Угтаал сум нь 270647.7 га нутаг дэвсгэртэй бөгөөд засаг захиргааны нэгж Ажирхай, Морьт, Хонгор гэсэн 3 багийн нийт 498 өрхөд 1544 хүн амьдардаг ба аймгийнхаа зүүн бүсийн тулгуур төвийн статустайгаар Улаанбаатар хотоос 260 км, Говьсүмбэр аймгийн төв Чойроос 92 км, Мандалговиос 110 км зайд оршин үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүн амын тоо жилээс жилд буурч байгаа нь Улаанбаатар хот, Говьсүмбэр аймагтай ойролцоо байршилтай, сумын газар нутгийн хэмжээ харьцангуй бага байдгаас отрын нөөц бэлчээр хомстой холбоотой олон малтай айл ялангуяа адуу оторлох зорилгоор бусад аймаг сумдад шилжин суурьших явдал ихэссээр байна. Өнөөгийн Говь-Угтаал суманд 320 хүүхдийн хүчин чадалтай ерөнхий боловсролын сургууль, 100 хүүхдийн цэцэрлэг, 10 ортой сум дундын нэгдсэн эмнэлэг, 250 хүний суудалтай соёлын төв, Засаг даргын Тамгын газар зэрэг улсын төсвийн байгууллагууд үйл ажиллагаагаа тогтмол явуулж иргэд хөдөлмөрчдөд төрийн үйлчилгээг хүргэж байна. Говь-Угтаал суманд ХААН банк, Төрийн банк, Угтаал-Ундрам хадгаламж зээлийн хоршоо зэрэг байгууллагууд, банк болон банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэдгээс гадна, үүрэн телефоны 4 оператор, худалдаа үйлчилгээний чиглэлээр “Угтаал трейд” ХХК, “Угтаал чандмань” ХХК, “Дэлгэр хонгор” ХХК-иуд үйл ажиллагаагаа явуулж байна. Тус сумын эдийн засгийн гол үндэс нь мал аж ахуй бөгөөд 180 гаруй мянган толгой малтай болсон байна.

Физик газарзүйн нөхцөл

Бумбатын жоншны орд газар нь Дундговь аймгийн Говь-Угтаал сумаас урд зүгт 32 км-т, Чойр төмөр замын өртөөнөөс 70 км-т, Улаанбаатар хотоос зүүн урагш 268 км-

Дундговь аймгийн Говь-Угтаал суманд байрлах MV-004386 тоот тусгай зөвшөөрөлтэй бумбатын хайлуур жоншны ордны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

т Мандалговь хотоос зүүн тийш 160 км зайд байрлана. Хэнтийн уулархаг мужийн өмнөд төгсгөл, тал хээрийн бүсэд хамаарагдана. Хамгийн өндөр уулсын хувьд Холбоо чулуу уул, Бага бор уул, Их бор уул зэрэг нь далайн түвшнээс дээш 1500м орчим байх ба уулархаг мужийн үнэмлэхүй өндөр нь 1200-1400м, харьцангуй дундаж өндөр нь 100-150м байна. Элс чулуурхаг хүрэн, хужир мараат хөрс, өндөр уулс нь боржингийн биетүүдээс тогтох ба орой нь шовх, бөмбөгөрдүү бөгөөд нарийн гуу, жалга ихтэй, хадан цохио элбэгтэй, тал хөндий нь дов толгодлог, гүвээ судаг ихтэй, өргөн, тэгш гадаргуутай. Ерлөг /1706м/ Их газрын чулуу /1566м/ Баянзүрх /1648м/ Их-Угтаал /1673м/ Сүмбэр цагаан уул /1408/ Хараат /1521м/ Цац /1469м/ Хонгор, Залаа, Даш-яйчил, Дулааны уул, Бичигтийн цохио, Их бага тал зэрэг уул тал хосолсон нутагтайгаас гадна, Сүмбэрийн цайдам говь, Шар, Бор Даравгай гурван дэлгэрийн тойром бүрд нуур Сүмбэрийн булаг, Баянбулаг, Дунд булаг, Могойн булаг, Цавчирын булаг Тал булаг зэрэг ундармал булаг шандуудтай. Хазаар өвс, хялгана ерхөг агь ганга таана хөмүүл дэрс бут хиаг зэрэг ургамалтай. Болор гартаам мана, хаш зэрэг эрдэнийн чулуу, Чулуун нүүрс, төмрийн хүдэр хайлуур жонш шохойн чулуу цайр мөнгө бал чулуу цахиур зэс зэрэг ашигт малтмалын илэрцүүд тогтоогдсон байдаг байна.

Уур амьсгал

Эх газрын эрс тэс уур амьсгалтай ба олон жилийн сарын дундаж температураар 7-р сард хамгийн дулаан +30.4, +35.9 хэм, 1-р сард хамгийн хүйтэн -24, -34 хэмд хүрдэг байна. Жилийн дундаж хур тунадас зуны улиралд 150-200 мм ба нийт тундасны 75% нь 7- 9-р саруудад буудаг. Өвлийн улиралд 75-125мм 10-р сарын дунд үеэс 2-р сар хүртэл алаг цоог цасан бүрхүүлтэй газрын хөрс 1.2м хүртэл хөлдөнө. Төсөл хэрэгжих нутагт олон жилийн дундажаар салхины хурд 3,5 /сек байна.

Усан орчин

Уурхайн ойр орчимд гадаргын ус (гол, горхи, нуур) байхгүй. Уурхайн ойролцоо олон тооны жижиг сайрууд байх боловч тэнд байнгын урсгал ус байдаггүй зөвхөн их устай ширүүн бороотой үед тэдгээрээр үерийн ус урсаж өнгөрдөг байна. Бумбатын ордын орчимд 4-5 гар худаг байх ба тэдгээрийн гүн нь 1-8 м байдаг. Олборлолтын үйл ажиллагааны үед ахуйн бохир ус, хатуу хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүн, шатах тослох материал ил задгай хаяж алдагдснаас хур борооны усаар угаагдан гүний усны чанарт шууд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Бумбатын ордын жоншыг ил далд хосолсон аргаар олборлоход техникийн зориулалттай усны хэрэглээ гарахгүй ба уурхайн кемпед шаардагдах унд ахуйн цэнгэг

Дундговь аймгийн Говь-Угтаал суманд байрлах MV-004386 тоот тусгай зөвшөөрөлтэй бумбатын хайлуур жоншны ордны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

усны хэрэглээ болон зам талбай, ногоон байгууламж, гал унтраах зэрэгт ашиглах техникийн усны хэрэглээ нийлээд 52.0 м³/хоног байна гэж тооцсон.

Хөрсөн бүрхэвч

Байгалийн бүсээр хээрийн бүсийн гандуу хээрийн дэд бүсэд хамаарах бөгөөд хөрс-газарзүйн мужлалтаар цайвар хүрэн хөрсний дэд бүс Баяндэлгэрийн 8-р тойрогт багтана. Эндэхийн ургамалшил тачир сийрэг зарим газраа ургамалгүй цулгүй байдаг учраас салхины үйлчлэлд хялбар өртөж хөрсний өнгөн хэсэг салхинд хийсч эвдрэх үйл явц элсэнцэр хөрстэй газраар байнга ажиглагдана. Орд орчмын газраар агь үетэн голлосон хуурай хээрийн ургамалшил зонхилж бүрхэц нь 20-40% хүрнэ. Энд сайргархаг болон карбонаттай цайвар хүрэн, хужирлаг шинжтэй цайвар хүрэн хөрс голлох суурийг эзлэхийн хамт гүвээ толгодоор нимгэн чулуурхаг цайвар хүрэн хөрс элбэг тархах ба толгодын орой бэлээр алаг цоог том валун чулууны илэрцтэй. Энд сайргархаг болон карбонаттай цайвар хүрэн, хужирлаг шинжтэй цайвар хүрэн хөрс голлох суурийг эзлэхийн хамт гүвээ толгодоор нимгэн чулуурхаг цайвар хүрэн хөрс элбэг тархах ба толгодын орой бэлээр алаг цоог том валун чулууны илэрцтэй. Цайвар хүрэн хөрс өвөл 2,5 3 м хүртэл гүн хөлдөх ба зун хур борооны ус хөрсөнд дөнгөж 15-20 см гүн нэвчиж чийглэгддэг онцлогтой.

Төслийн үйл ажиллагаанаас шалтгаалж бэлчээр нутаг хумигдах гол сөрөг нөлөөлөл байна. Мөн техникүүд тогтоосон маршрутаар зорчихгүй байх, хөрс хуулалтыг эмх замбараагүй явуулах, хог хаягдлыг төвлөрсөн цэгээс өөр газарт хаях, хадгалах, техникийн засвар үйлчилгээг зориулалтын бус газарт хийх зэргээс үүдэн хөрс доройтох, газрын хэвлийд сөрөг нөлөөлөх боломжтой байна

Ургамлан нөмрөг

Дундговь аймгийн Говь-Угтаал сум нь Н.Өлзийхутагийн (1989) ангилсан ургамал-газарзүйн мужлалын 16 тойргийн Дундад Халхын хээрийн тойрог, Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт багтдаг боловч “Хараат уул”-ын цайр, төмрийн орд нь Дундад Халхын хээрийн тойрогт хамаарагдах бөгөөд талбайн ургамлан нөмрөгийн хувьд хээрийн ургамал зонхилон тохиолдох бөгөөд өвслөг ургамлаас крыловын Хялгана /*Stipa krylovii*/, сөөглөг ургамлаас бяцхан навчит Харгана /*Caragana microphylla*/ ургамлаас хагас сөөгөнцөр ургамлаас агь Шарилж /*Artemisia frigida*/ зэрэг ургамлууд зонхилон ургадаг.

Олборлолтын үйл ажиллагааны үед талбайн хэмжээгээр ургамлан нөмрөг устгах, олборлолтын үйл явц болон тээвэрлэлтийн үед гарсан тоосжилтоос үүдэн ургамлын фотосинтез зогсох, ургах орчин, чадвар муудах, хог хаягдлыг эмх замбараагүй орхих,

Дундговь аймгийн Говь-Угтаал суманд байрлах MV-004386 тоот тусгай зөвшөөрөлтэй бумбатын хайлуур жоншны ордны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

шатах тослох материалын асгаралт үүсэх зэргээс ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна. Иймд олборлолтын үйл ажиллагаанд ургамал хамгааллын арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлснээс нөлөөллийн эрчим шууд хамаарна.

Амьтан

“Бумбатын”-ын орд газар болон түүний орчмын нутгаас судалгааны явцад 5 багт хамаарах 16 зүйл тэмдэглэгдсэнээ шавьж идэштэн 1, далавчтан 3 махчтан 3 туулайтан 2, мэрэгчтэн 7 зүйл байна.

Бумбатын ордын ашиглалтаас дараах байдлаар амьтны аймагт нөлөөлөл үзүүлэхээр байна. Үүнд:

- Олборлолтын үйл ажиллагааны улмаас хөрсний доройтлоос шалтгаалж мөлхөгчид, хэвлээр явагч болон шавьжнуудын амьдрах орчинд нөлөөлж тоо толгой нь багасах.
- Олборлолтын үйл ажиллагааны улмаас (тэсрэлт, дэлбэрэлт, чимээ шуугиан, гэрэл, машин техникийн үйл ажиллагаа) ашиглалтын талбайгаас шувуу, урт хөлийн амьтад дайжиж үгүй болох.
- Түүнчлэн төслийн дэд бүтэцтэй холбоотойгоор амьтдын амьдрах орчин алдагдах,
- Техноген болон хүний өөрчилсөн орчинтой холбоотойгоор зарим нэг шинэ зүйлийн шавьжнуудын тоо толгой өсч болох.
- Биологийн төрөл зүйлийн нэгийг нөгөөгөөр орлуулж болдоггүй, бие биенийхээ хэвийн амьдралаас шууд шалтгаалан экологийн тэнцэлд зохицон байдаг гинжин хэлхээ тасрахаар экологийн тэнцэл алдагдаж тэнд амьдралгүй болдог зүй тогтол үүсэх.
- Шинээр ирж ажиллаж суурьших хүмүүс зэрлэг ан амьтдыг хууль бусаар агнаж болзошгүй.

Агаар орчин

Агаарын бохирдолт гэдэг нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад үүссэн хорт хий, тоос болон бусад бодисын нөлөөгөөр агаарын чанарын хүлцэх хэмжээнд гарсан өөрчлөлт юм.

Төслийн ТЭЗҮ-ийн мэдээлэл болон эх үүсвэрийн ялгарлын холбогдох гарын авлагуудын арга зүйг ашиглан тооцоолол хийж тархалтын загвараар уурхайн агаар бохирдуулагч бодисын нөлөөллийг тооцоолсон. Тархалтын загварын үр дүнгээс үзэхэд төслийн гол агаар бохирдуулагч бодис болох тоос тоосонцор уурхайн овоолгын үйл ажиллагаа болон гадаад дотоод тээвэрлэлт, техник хэрэгслийн хөдөлгөөн, “ХАН ХАС ТРЕЙД” ХХК

Дундговь аймгийн Говь-Угтаал суманд байрлах MV-004386 тоот тусгай зөвшөөрөлтэй бумбатын хайлуур жоншны ордны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

баяжуулах процессоос үүдэх тоосжилт зэрэг болно. Мөн хайгуулын ажлын дээжлэлтийн түүхий эдийг тээвэрлэх том оврын авто тээврийн хэрэгслүүд болон бусад тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах хийн хаягдал нь агаар орчинд бохирдол үүсгэнэ.

Уурхайн ухаш олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх тоос, тоосонцор стандартын ЗДХ-д орчны агууламжийг нэмэгдүүлж байна. “ХанХас трейд” ХХК-ийн зүгээс тоос, тоосонцор дарах усалгааг тогтмол хийх, тоосжилт бууруулах зааварчлагаанд дурдсан арга хэмжээг авж ажиллах шаардлагатай.

Хүснэгт 1. Шатахууны зарцуулалтаар ялгарах хорт бодисын хэмжээ

| № | Хорт бодис | Шатахууны төрөл | |
|---|----------------------------|-----------------|-------------|
| | | Бензин | Дизель түлш |
| | | г/кг | |
| 1 | Нүүрстөрөгчийн давхар исэл | 225 | 20-30 |
| 2 | Азотын давхар исэл | 55 | 20-40 |
| 3 | Нүүрстөрөгч | 20 | 4-10 |
| 4 | Хүхэрлэг хий | 1.5-2.02 | 10-30 |
| 5 | Хөө тортог | 1-1.5 | 3-5 |
| 6 | Хартугалга | 0.5-0.85 | - |
| 7 | Бенз-а-пирен | 0.23 | 0.31 |
| 8 | Альдегид | 0.8-1.0 | 0.8-1.0 |

Түүх, соёлын дурсгалт зүйлс: “Ханхас трейд” ХХК нь Монгол Улсын “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн 6 дугаар бүлгийн 17 дугаар зүйлийн 10-т заасны дагуу ашиглалтын талбайд археологийн хайгуул судалгаа хийлгэсэн. Хайгуул судалгааны явцад ямар нэгэн түүх соёлын дурсгал илрээгүй.

Тусгай хамгаалалттай газар нутаг

Бумбатын хайлуур жоншны уурхайн талбайгаас 130 км-ын зайд улсын тусгай хамгаалалттай “Загийн Усны байгалийн нөөц газар”, 75 км –ын зайд “Их Нартын байгалийн нөөц газар”, “Их бага газрын чулуу байгалийн нөөц газар” 50 орчим км-ын зайд тус тус байрлаж байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Ашиглалтын үйл ажиллагааны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь энэхүү төслийг хэрэгжүүлэх үед олборлолтын ажлын онцлогоос хамааран газрын хөрс, түүний дээрх ургамал, газрын хурдас болон агаар мандалд тоос босох зэрэг сөргөөр нөлөөлөх тул байгаль орчны мониторингийг тогтмол хийх, түүнийг нөхөн сэргээх ажлыг байгаль хамгаалах төлөвлөгөө, санхүүжилтэндээ тусган гүйцэтгэж ажиллана.

Дундговь аймгийн Говь-Угтаал суманд байрлах MV-004386 тоот тусгай зөвшөөрөлтэй бумбатын хайлуур жоншны ордны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт

MV-004386 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий хайлуур жоншны ордын төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг “Их зос” ХХК-иар 2019 онд хийлгэсэн. Тус үнэлгээний үр дүнг тоймлон авч үзэхэд Бумбатын хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд анхаарах шаардлагатай асуудлууд болон гол чухал зорилтууд нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд: Уурхайн хайгуулын ажлын үйл ажиллагааны улмаас өртөгдөх, газрын хэвлийд олборлолтын ажлын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд холбогдох аргачлал, стандартын явуулна.

Олборлолтын ажлын үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдалтай холбоотойгоор хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, үүсэх хог хаягдлыг багасгах, төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэх дарж булах, аюлтай хог хаягдлыг холбогдох мэргэжлийн байгууллагад шилжүүлэх ажлыг зохион байгуулна. Орчны хяналт шинжилгээг хуваарийн дагуу явуулж уурхайн үйл ажиллагаанаас үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөлд хяналт тавих болно.

Дундговь аймгийн Говь-Угтаал суманд байрлах MV-004386 тоот тусгай зөвшөөрөлтэй бумбатын хайлуур жоншны ордны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хамрах хүрээ

Агаар: “Ханхас трейд” ХХК нь уурхайн цэгэн эх үүсвэрүүдээс үүсэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, хамрах эрчим, хэмжээг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг 2023 оны олборлолтын ажлын үед авч хэрэгжүүлж ажиллана.

Хөрс, газрын гадарга: Уурхайн олборлолтын ажлыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ. Уурхайд олон салаа зам гаргахгүйн тулд дотоод замыг стандартын дагуу байгуулж, тоосжилтыг бууруулах ажлыг зохион байгуулна.

Усан орчин: 2023 онд зам талбайн тоос дарж, уснаас дээж авч шинжлүүлэх ажлыг байгаль орчны нарийвчилсан үнэлгээний дагуу орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

Ургамлан нөмрөг: Хөрс хуулалтанд өртөж байгаа газрын шимт хөрсийг тусад нь хадгалж биологийн нөхөн сэргээлтэнд ашиглана.

Амьтан: Төслийн үйл ажиллагааны улмаас амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг бууруулах, тухайн сонгон авсан талбайд амьтдын амьдрах орчинг сайжруулах талаар зохион байгуулна.

Хог хаягдал

Уурхайн 40 хүн ажиллана гэж үзэн 1 хүнээс хоногт дунджаар 0,5 кг хатуу хог хаягдал гарна гэж тооцвол өдөрт 20 кг болно. Одоогийн ахуйн хатуу хог хаягдлын цэгийг шинэчлэн байгуулах шаардлагатай.

Зам

Төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолоор батлагдсан “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам”-ын дагуу гадаад тээврийн авто замын чиглэл, ТЭЗҮ-ийг батлуулан тухайн авто зам, замын байгууламжийг барих, ашиглах гэрээг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай байгуулан ажиллах нь зүйтэй.

Дундговь аймгийн Говь-Угтаал суманд байрлах MV-004386 тоот тусгай зөвшөөрөлтэй бумбатын хайлуур жоншны ордны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1.9

| № | Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ | Хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал | Хэрэгжүүлэх хугацаа давтамж | Баримтлах эрхзүйн бичиг баримт |
|-------------------------------------|--|---|----------------|------------------------|------------|-------------|-----------------------------|---|
| Агаарын чанар | | | | | | | | |
| 1 | Уурхайн технологийн зам, олборлолтоос үүсэх тоосжилт, хуурайшилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх, | Уурхайн орчимд | ш | - | 1 | - | 2023 | “Агаарын тухай”, MNS 0017-2-3-16:1998 (суурьшлын хэсгүүдэд) MNS 4585:2008 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. |
| 2 | Ойн зурвас байгуулах | Уурхайн орчимд | ш | 2000 | 1600 | 3.200.0 | 2023 | Ойн тухай хууль |
| Гадаргын ба газрын доорхи усны нөөц | | | | | | | | |
| 3 | Уурхайн орчмын 2 гүний худагт худагт мониторингийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх | Гүний худгуудыг мониторинг хэмжилт хийх | ш | 500.0 | 1 | 500.0 | 2023 | Усны тухай хууль, MNS 0900:2015 |
| Хөрсөн бүрхэвч | | | | | | | | |
| 5 | Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах ба уг үйл ажиллагаанд хяналт тавих. 2023 оны нийт хугацаанд нь үржил шимт хөрс хуулна. | Шимт хөрсний овоолго | М ² | - | - | - | 2023 | Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль |
| 6 | Ариун цэврийн байгууламжийг био 00 шийдвэрлэх | Хөрсний бохирдлоос хамгаалах | Ш | 1000.0 | 1 | 1000.0 | 2023 | |
| Газрын хэвлий | | | | | | | | |
| 7 | Жонш тээвэрлэлтийн сайжруулсан автозамыг засаж сайжруулах | Төслийн хүрээнд | км | - | | - | 2023 | Газрын хэвлийн тухай хууль |
| Амьтны аймаг | | | | | | | | |

Дундговь аймгийн Говь-Угтаал суманд байрлах MV-004386 тоот тусгай зөвшөөрөлтэй бумбатын хайлуур жоншны ордны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

| | | | | | | | | |
|---|-------------------------------|--|--------|------|----|-------|------|--------------------|
| 8 | Биотехникийн арга хэмжээ авах | Төслийн талбай орчим болон бага газрын чулуунд | Боодол | 10.0 | 50 | 500.0 | 2023 | Амьтны тухай хууль |
|---|-------------------------------|--|--------|------|----|-------|------|--------------------|

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1.10

| № | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал | Хэрэгжүүлэх хугацаа | Баримтлах эрхзүйн бичиг баримт |
|---|--|---|-------------|------------------------|------------|-------------|---------------------|---|
| 1 | Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Бага газрын чулуу, Сайнцагаан сумын хаалгын хад тусгай хамгаалалттай газруудад зэрлэг ан амьтан ажиглах камер байршуулах | Зэрлэг ан амьтан ажиглах камер байршуулах | ш | 400.0 | 6 | 2400.0 | 2023 | БОНХАЖЯ-ны сайдын 2014-01-10-ны өдрийн А11 тушаалын 2-р хавсралт, 3-р хэсэг. БОНҮ-ний аргачлал. БО-ыг хамгаалах тухай хууль, MNS 5973 : 2009, MNS 6258 : 2011 |

ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1.11

| № | Урьдчилан сэргийлэх арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал мян.төг | Нийт зардал | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрхзүйн бичиг баримт |
|---|---|--------------------------|------------|------------------------|-------------|--------------------------------|---|
| 1 | ХАБЭА-н дүрэм, Галын аюулаас хамгаалах, Аваар устгах төлөвлөгөөг ажилчдад танилцуулж шалгах, ХАБЭА-н сургалт хийх | Уурхайн ажилчдад | 2 | 500.0 | 1000.0 | 2023 | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны тухай хууль, MNS ISO 45001:2019 |
| 2 | Ажилчин нэг бүрийг хөдөлмөр хамгааллын | Уурхайн ажилчдад | 20 | 100.0 | 2000.0 | 2023 | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны |

Дундговь аймгийн Говь-Угтаал суманд байрлах MV-004386 тоот тусгай зөвшөөрөлтэй бумбатын хайлуур жоншны ордны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

| | | | | | | |
|---------------------------------|--|--|--|--|--|----------------------------|
| хувцас, багаж хэрэгслээр хангах | | | | | | тухай хууль, MNS 4990:2015 |
|---------------------------------|--|--|--|--|--|----------------------------|

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1.12

| № | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал | Хэрэгжүүлэх хугацаа | Баримтлах эрхзүйн бичиг баримт |
|---|---|--|-------------|------------------------|------------|-------------|---------------------|--------------------------------|
| 1 | Энгийн хог хаягдлыг ангилах, нэгдсэн цэгт тээвэрлэх, хог хаягдлын гэрээ байгуулах арга хэмжээг зохион байгуулах | Уурхайн орчимд | Тн | - | - | - | 2023 | Хог хаягдлын тухай хууль |
| 2 | Аюултай хог хаягдлын бүртгэлийг тогтмол хийх, бүртгэлийн код авах | Уурхай үүссэн аюултай хог хаягдлыг бүртгэлжүүлэх | ш | - | - | - | - | Хог хаягдлын тухай хууль |

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1.13

| № | Шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал төг | Нийт зардал төг | Тайлбар | Баримтлах стандарт аргачлал |
|-------------------|---|-------------------------------------|--------------------|----------------|--------------------|-----------------|---------|-----------------------------|
| Агаарын шинжилгээ | | | | | | | | |
| 1 | Агаар дахь тоосжилтын хяналт: Нийт тоос PM2.5, PM10 | Бохирдуулагч эх үүсвэрүүдийн орчинд | Жилдээ | 2 | 300.0 | 600.0 | - | MNS 4585:2016 |
| 2 | Агаар дахь хүлцэх агууламжийг тодорхойлох NO _x SO _x CO _x | Бохирдуулагч эх үүсвэрүүдийн орчинд | Жилдээ | 2 | 300.0 | 600.0 | - | MNS 4585:2016 |
| Дуу шуугиан | | | | | | | | |

Дундговь аймгийн Говь-Угтаал суманд байрлах MV-004386 тоот тусгай зөвшөөрөлтэй бумбатын хайлуур жоншны ордны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

| | | | | | | | | |
|------------------------------|--|--|--------|---|--------|--------|--|---------------|
| 3 | Дуу шуугиан чичиргээ | Тээврийн замын дагуу | Жилдээ | 2 | 400.0 | 800.0 | | MNS 4585:2016 |
| Газрын доорхи ус | | | | | | | | |
| 4 | Усны чанарын стандартад заасан үзүүлэлтүүд | Уурхайд ашиглагдаж буй худаг ба малчдын ойр орчмын худгууд | Жилдээ | 1 | 500.0 | 500.0 | | MNS0900:2015 |
| Хөрсөн бүрхэвч | | | | | | | | |
| 5 | Хөрсний эвдрэл гэмтэл | Уурхайн орчимд гол замууд | Жилдээ | 2 | 500.0 | 500.0 | | MNS5546:2005 |
| Ургамлан бүрхэвчийн судалгаа | | | | | | | | |
| 6 | Ургамлын суурь судалгаа | Уурхайн орчимд | Жилдээ | 1 | 1000.0 | 1000.0 | | |

ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1.14

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Хэрэгжүүлэх хуваарь | | Хариуцсан албан тушаалтан | Тайлбар |
|---|--|-------------------------|---------------------|-----------|--------------------------------|---------|
| | | | 2023 он | | | |
| | | | Хагас жил | Бүтэн жил | | |
| 1 | Байгаль орчныг хамгаалах, уурхайн бүтээн байгуулалттай холбоотой дэд бүтцийг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагтай хамтран ажиллах гэрээг байгуулах | - | 50% | 50% | Төсөл хэрэгжүүлэгч байгууллага | |

Дундговь аймгийн Говь-Угтаал суманд байрлах MV-004386 тоот тусгай зөвшөөрөлтэй бумбатын хайлуур жоншны ордны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ Хүснэгт 1.15

| № | БОХТ-ийн биелэлтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацааны тов | Тайлагнах зардал.төг | Хариуцан зохион байгуулах ажилтан, албан тушаалтан | Зохион байгуулах газар |
|---|---|-------------------------|-------------------------------------|--------------------------------|----------------------|--|---------------------------------|
| | Төсөл хэрэгжүүлэгч байгууллага, нөлөөллийн бүсийн иргэд | Багийн иргэдийн хурлаар | БОХТөлөвлөгөө ний биелэлтийн тайлан | 2023 оны 10.20 | 1000.0 | Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын удирдлага, Байгаль орчны мэргэжилтэн | Төсөл хэрэгжүүлэгч байгууллагад |

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ НИЙТ ТӨСӨВ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв

Хүснэгт 1.16

| № | Зардлын ангилал | Зардал мян.төг |
|---|---|----------------|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 5200.0 |
| 2 | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | 2400.0 |
| 3 | Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө | 3000.0 |
| 4 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | - |
| 5 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө | 4000.0 |
| 6 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | - |
| 7 | Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө | 1000.0 |
| | Нийт зардал | 15600.0 |

Бумбатын хайлуур жоншны уурхайг ил далд аргаар олборлох төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 15600.0 /Арван таван сая зургаан зуун / мянган төгрөг зарцуулах урьдчилсан тооцоо гарч байна.